



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2018 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 01

Бүрхээр

Могойн гол ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит 24 дүгээр хурал 2018 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум, Могойн гол ХК-ийн байранд 12⁴⁰ цагт эхлэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит 24 дүгээр хурлын тооллогын комисс хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг тогтоож хурлын даргад мэдээллэв. /Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав/ Нийт **829622** /найман зуун хорин ес зургаан зуун хорин хоёр/ ширхэг хувьцаа эзэмшиж буй 939 хувьцаа эзэмшигчдээс **757984** ширхэг хувьцаа эзэмшиж буй 8 хувьцаа эзэмшигч биеэр оролцсон. Саналын хуудсаар саналаа өгсөн 2 хувьцаа эзэмшигч. Монгол улсын компанийн тухай хуулийн 69 дугаар зүйлийн 69.1, Могойн гол ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дэхь заалтыг хангасан учир тооллогын комисс хурлын ирцийг баталж хурлын даргад мэдээллэв. /Тооллогын комиссын тогтоол хавсаргав./

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит 24 дүгээр хуралд: Хувьцаа эзэмшигч

№	Овог нэр	Төлөөлөл	Регистерийн дугаар	Хувьцааны тоо
1	Цэрэнтогтох овогтой Баттогтох	Орон нутгийн өмчийн 51%-ийг итгэмжиллээр төлөөлөгч		423107
2	Ж.Батболд		TE64010314	135451
		Булган Брокер	2008157	4280
3	Г.Бадрал-Эрдэнэ		PM76062213	5
		Транс нефть ХХК	204660399777	124444
		Могойн гол энержи ХХК	5361699	26492

4	Л.Батдэлгэр		ЙТ54081510	23067
5	Ч.Гүнсээноров		ЙТ60021503	15098

Тооллогын комиссын дарга: Г.Өнөржаргал

Компанийн нягтлан бодогч: Л.Шинэцэцэг

Тооллогын комиссын гишүүн Л.Амарболд /Хараат бус гишүүн/, Нэр дэвшүүлэх хорооны дарга, ТУЗ-ийн гишүүн Ц.Бэхбаяр, Хараат бус гишүүн С.Баясгалан, ТУЗ-ийн гишүүн Ж.Дагважамц, гүйцэтгэх захирал Б.Хашбат, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Ичинхорлоо нар оролцов.

Хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн ээлжит 24 дүгээр хурлаар хэлэлцэхээр Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө болон хурлын дэгийг танилцуулж хурлыг нээж асуух асуулт гаргахыг мэдэгдэв.

МОГОЙН ГОЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1. Хурлын ирц бүртгэх / ажлын хэсэг/ 12:00-12:10
 2. Хурлын ирц мэдээлэх /ажлын хэсэг/ 12:10-12:15
 3. Хурлын дарга хурал нээх хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах 12:15-12:25
 4. Үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт , 12:25-12:35
 5. Асуулт хариулт, санал дүгнэлт 12:35-12:50
 6. Санал хураалт 12:50-13:00
 7. ТУЗ-ийн 2017 оны зардлын төсөвийн тухай 13:00-13:10
 8. Асуулт хариулт, санал дүгнэлт 13:10-13:20
 9. Санал хураалт 13:20-13:30
 10. 2017 оны ногдол ашиг хуваарилах тухай 13:30-13:40
 11. Асуулт хариулт санал дүгнэлт 13:40-13:50
 12. Санал хураалт 13:50-14:00
 13. Хөрөнгө данснаас хасах тухай 14:00-14:10
 14. Асуулт хариулт санал дүгнэлт 14:10-14:20
 15. Санал хураалт 14:20-14:30
 16. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай 14:30-14:40
 17. Асуулт хариулт санал дүгнэлт 14:40-14:50
 18. Санал хураалт 14:50-15:00
 19. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах 15:00-15:10
 20. Хурлаас гарах шийдвэрт тогтоолыг танилцуулах 15:10-15:55
- Хурлыг хаах /хурлын дарга / 10 минут

ХЭЛЭЛЦСЭН нь 1: Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт

СОНССОН нь: ТУЗ-ийн тайланг ТУЗ-ийн дарга Ц.Баттогтох танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав. /

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид уулын ажлын өрнөлт, үйл явцтай танилцав.

Хурал даргалагч хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, санал дүгнэлт гаргахыг мэдэгдэв.

Ж.Батболд: Хувьцаа эзэмшигчдийн хурлыг компани дээр ирж хийж буй явдалд баяртай байна. Өнгөрсөн хугацаанд ТУЗ-ийн гишүүд компанийн зорилго тодорхойлж, цаашдын том зорилгыг эхлүүлэх жил болж өнгөрч байна. Ижил төстэй байгууллагууд болон гадаадад тоног төхөөрөмж, техник хэрэгсэл судалж ажилласан. 2017 оны үр дүнг хэлэлцэж, 2018 оны зорилгыг тодорхойлсон. Төлөвлөлтийг зөв хийж явахгүй бол уулын ажил хүндэрнэ. Өнгөрсөн хугацаанд ТУЗ эрх зүйн хувьд чухал шийдвэрүүдийг гаргаж ажилласан. Нүүрсийг экспортод гаргах, нүүрсний үнэ нэмэх зэрэг шийдвэрүүдийг гаргаж ажилласан. Цаашид зорилтоо улам нэмэгдүүлж өнөөгийн түвшнээс хоёр дахин нэмэгдүүлэх шаардлагатай байна. ТУЗ өнгөрсөн хугацаанд хангалттай ажилласан гэж үзэж байна.

Л.Батдэлгэр: Дараах саналууд байна.

1. ТУЗ-ийн хурлыг тогтмолжуулах шаардлагатай байна. Шаардлагатай үед Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлаж болно.

2. ТУЗ-ийн хурлыг үйлдвэр дээрээ хагас жилдээ юм уу улиралдаа нэг удаа хийж байх хэрэгтэй.

3. Гүйцэтгэх удирдлага ТУЗ-ийн хурлаас өгсөн үүрэг даалгавруудын биелэлтийг тухай бүр нь танилцуулж байх.

Ц.Баттогтох: 2017 онд уурхай үйл ажиллагаа амжилттай ажилласан жил байлаа. 2018 онд томоохон зорилтыг тавьж байгаа. Ажлыг улам эрчимжүүлэх шаардлагатай байна. ТУЗ-ын болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр компанийн гүйцэтгэх удирдлагын багийг бүрэн оролцуулж байх хэрэгтэй. Шаардлагатай мэдээллийг сонсох гэхээр хариуцсан ажилтан нь алга байдаг. ТУЗ-ийн хурлыг цаашдаа тогтмолжуулж ажиллана. Дүрмэнд 2 сар тутамд гэсэн байгаа. ТУЗ-ийн гишүүдийн ажлыг цаг завьг харж байж хурлыг товлдог. Энэ жил бизнесийн хувьд илүү боломжууд харагдаж байна. Үнийг хөдөлгөх боломж бол

байгаа. 2017 он үр дүн сайн байсан. 2018 онд илүү амжилттай ажиллана гэж үзэж байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Тогтоолын төсөл танилцуулав. Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигч саналын хуудсаа ирүүлсэн. /Саналын хуудас хавсаргав/

ХЭЛЭЛЦСЭН нь 2: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны зардлын төсөв батлах тухай

СОНССОН нь: Хурал даргалагч хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, санал гаргахыг мэдэгдэв.

Ж.Батболд: Дараах саналууд байна.

1. ТУЗ-ийн гишүүдийг цалинг 100-200 мянгаар нэмж 500,0-600,0 мянга болгох саналтай байна.

2. Энэ жилийн төлөвлөгөөнд гадагш явж туршлага судлах асуудал байгаа бил үү. Цаашид далд хэлбэрээр уулын ажил явуулах шаардлага гарч болзошгүй тул уулын ажлын технологийн хэлбэрийг өөрчлөхтэй холбоотой ТУЗ-ийн гишүүд судлах шаардлагатай тул ТУЗ-ийн бусад зардалд 20,000\$ төсөвлөх саналтай байна.

Г.Бадрал-Эрдэнэ : Энэ саналыг дэмжиж байна.

Л.Батдэлгэр: Энэ саналыг дэмжиж байна.

Ц.Баттогтох: ТУЗ-ийн гишүүдийн цалинг энэ жилээс нэмж байгаа тул ойрхон ахин нэмэхгүйгээр 400,0-аар нь байлгаад дараа жилээс уурхай амжилттай ажиллавал нэмэх боломж бий. ТУЗ-ийн бусад зардлыг 20,000 мян төгрөгөөр тогтоох саналтай байна.

Л.Батдэлгэр: Дунджаар нь 30,000 мян төгрөг болгоё.

ТУЗ-ийн гишүүдийн цалинг 400,0 мянга, ТУЗ-ийн бусад зардлыг 30,000 мян төгрөгөөр тогтоох томъёоллоор санал хурааж хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид дэмжив.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Тогтоолын төслийг танилцуулав. Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигч саналын хуудасаа ирүүлсэн. /Саналын хуудас хавсаргав/

ХЭЛЭЛЦСЭН нь 3: Хөрөнгө данснаас хасах тухай

СОНССОН нь: Хурал даргалагч хэлэлцэж буй асуудлыг танилцуулж, холбоотой асуулт, санал, дүгнэлт гаргахыг мэдэгдэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Тогтоолын төслийг танилцуулав. Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигч саналын хуудасаа ирүүлсэн. /Саналын хуудас хавсаргав/

ХЭЛЭЛЦСЭН нь 4: Ногдол ашиг хуваарилах ТУЗ-ийн шийдвэрийг мэдээллэх тухай

СОНССОН нь: ТУЗ-ийн дарга ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулав. /ТУЗ-ийн тогтоол хавсаргав./

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Тогтоолын төсөл батлав. Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигч саналын хуудсаа ирүүлсэн. /Саналын хуудас хавсаргав/

ХЭЛЭЛЦСЭН нь 5: ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

СОНССОН нь: Нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт танилцуулав. /Хавсаргав./

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Тогтоолын төсөл батлав. Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигч саналын хуудсаа ирүүлсэн. /Саналын хуудас хавсаргав/

Хурал даргалагч Ц.Баттогтох хурлын талаарх санал дүгнэлт хэлэхийг мэдэгдэв.

Л.Батдэлгэр: Худалдан авах ажиллагаатай холбоотой өнгөрсөн жилийн тайлан, үр дүн гэрээний биелэлтийг тухай бүрд нь ТУЗ-д танилцуулж байх хэрэгтэй байна.

Ж.Батболд: Хурал амжилттай боллоо. Шинээр болон улиран сонгогдсон ТУЗ-ийн гишүүдэд баяр хүргэе. Цаашид нэг баг болон хамтран ажиллацгаая. Бизнес төлөвлөгөөг шаардлагатай бол ахин хэлэлцэж болно.

Ж.Дагважамц: ТУЗ-ийн үүргийн тухайд ажилчдад танилцуулах хэрэгтэй.

Ц.Баттогтох: Хурал амжилттай боллоо. Өнгөрсөн жил бид амжилттай ажилласан. Энэ жил ахиулж ажиллана. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, ажилчид хамтран энэ жил үйл ажиллагааны цар хүрээгээ өргөтгөж ажиллана.

Шинээр байгуулагдсан ТУЗ-д амжилт хүсч хурал хаав.

Хурал 17цаг 10 минутад тарав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Г.ИЧИНХОРЛОО

ТАНИЛЦСАН:
ДАРГА Ц.БАТТОГТОХ

